

## ОРОСЫН ИСЛАМЫН ТҮҮХ, СОЁЛЫН СУДАЛГААНЫ ШИНЭ БҮТЭЭЛИЙН ТУХАЙД

*Дашнямын Д.Золбоо*

*ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, доктор (Ph.D), дэд профессор  
zolbood@mas.ac.mn*

*Хураангуй: Зохиогч энэхүү тойм өгүүлэлд оросын ислам судлалын нэрт мэргэжилтэн эрдэмтэд хамтран туурвиж ОХУ-ын ШУА-ийн Дорно дахин судлалын хүрээлэнгээс 2018 онд хоёр дахь удаагийн хэвлэлээр гаргасан “Оросын ислам. Түүх ба соёлын найруулал” гэсэн судалгааны том хэмжээний нэгэн сэдэвт хамтын бүтээлийн өмнөх үг, удиртгал, нийт 12 бүлэг ба дүгнэлтийн агуулга, авч үзсэн асуудал, зохиогчдоос дэвшүүлэн тавьсан үзэл санаа, дүгнэлтийг уншигчид тодорхой хэмжээний ойлголттой болохуйц байдлаар тоймлон өгүүлсэн болно. Зохиогч энэхүү танилцуулгадаа уг хамтын бүтээлийн шинэлэг тал, Орос дахь ислам шашны түүх, соёл, орчин үеийн асуудлын судалгаанд оруулсан үнэтэй хувь нэмэр, эрдэм шинжилгээний ач холбогдол, үнэ цэнийг дурдаж тэмдэглэхийг зорьжээ.*

Миний бие энэ оны 6 дугаар сард ОХУ-ын Буриад улсын Улаан-Үд хотноо ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Будда, Төвөд судлалын хүрээлэнгийн 100 жилийн ойн арга хэмжээнд оролцож, улмаар Москва хотод ОХУ-ын ШУА-ийн Дорно дахин судлалын хүрээлэнд томилолтоор ажиллан эрдэм шинжилгээний зохион байгуулалт, гадаад харилцаа, хамтын ажиллагаатай танилцаж дорно дахин судлал, түүний дотор монгол судлалын зарим нэрт эрдэмтэдтэй уулзаж санал бодол солилцох, тус хүрээлэнгээс хэвлүүлж гаргасан судалгааны нэг

сэдэвт бүтээл, бусад ном зохиол олж үзэж хүрээлэнгийн номын сандаа авчрах завшаан олдсон юм. Тухайлбал, тус хүрээлэнгийн захирал байсан, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, хүрээлэнгийн тэргүүлэх зөвлөх, араб судлаач эрдэмтэн, академич В.В.Наумкин, хүрээлэнгийн захирал, ислам шашны түүх, соёлын асуудлаар дагнан судалдаг эрдэмтэн, түүхийн шинжлэх ухааны доктор, профессор А.К.Аликберов нартай уулзаж санал бодол солилцов.



Дорно дахин судлалын хүрээлэн нь араб, түүний дотор ислам шашин судлалаар дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн, 200-аад жилийн баялаг уламжлалтай эрдэм ухааны тэргүүлэх төв юм.

Хүрээлэнгийн удирдлагаас бэлэглэсэн ном бүтээлийн дотор “Российский ислам. Очерки истории и культуры” (“Оросын Ислам: Түүх ба соёлын найруулал”) хэмээх томоохон хэмжээний хамтын судалгааны үр дүн болсон нэгэн сэдэвт бүтээл багтжээ. Миний хувьд хэдийгээр шашин, түүний дотор Ислам шашин судлаач мэргэжилтэн биш хэдий ч уг бүтээл анхаарал сонирхол татсан билээ. Энэ нь олон улсын харилцаа, орон судлалаар судалгаа хийх явцад тухайн улс орны шашин, соёлын асуудлыг давхар авч үзэх шаардлага гардагтай холбоотой байсан болов уу. Тус бүтээлийг хэдэн хоног хэрдээ анхааралтай үзэж танилцсан маань зарим зүйлд ач тустай болов. Улмаар ахмад эрдэмтэн А.Жамбал багштай зөвлөлдөн дэмжлэг хүссэний дүнд энэхүү товч танилцуулгыг бэлтгэлээ.

Тэр тухайд өгүүлэхийн өмнө урьдчилан тэмдэглэхэд ер нь түүх, соёл, шашны аль нэгэн чухал асуудлыг энэхүү хамтын бүтээлийн дайтай нягт нямбай шинжлэн боловсруулж бусад судлаач эрдэмтэд, уншигчдын анхаарлыг татахуйц байдлаар, шинжлэх ухаанч зарчмыг баримтлан эрдэм шинжилгээний өндөр түвшинд туурвихыг бидний үеийн эрдэмтэн судлаачид ямагт хичээх хэрэгтэй юм даа гэсэн бодол санаа төрж, энэ талаар урьд нь бодож явдаг байсан санаа бодлыг минь улам өдөөх шиг болов. Уншигчид энэ өгүүлбэрийг уншаад “гадаад дотоодод гарч л байдаг олон сайн бүтээлүүдийн нэгийг онцлон магтаж жишиг болох утгатай үг яриа гаргаж байгаа нь ямар учиртай юм бол” гэж

бодож болох юм. Гэвч мэргэжлийн туршлагатай судлаач эрдэмтэд асуудалд өөр байдлаар хандгагийг хэлэх хэрэгтэй. Тэдний хэн нь ч гадаад орнуудад эрдэм шинжилгээний томилолтоор ажиллах, томоохон хурал, санал солилцох уулзалт, ярилцлагад оролцсоноор, эсвэл сонирхож судалдаг сэдэв, асуудлаар нь гарсан ямар нэг чухал бүтээлийг олж танилцсанаар ухаан бодол, сэтгэл сэргэж урам ордог доо! Эл бэсрэг тэмдэглэлд дээр нэр дурдсан бүтээлийн талаар бидний өгүүлэх санаа бодол бол тийм л урам сэргээсэн сэтгэгдлээр илэрхийлж бичсэн зүйл болно.

Авч үзэн буй бүтээлийг орос нэрээр нь бүрэн нэрлэвэл: Российский ислам. Очерки истории и культуры. Второе издание, исправленное и дополненное. Группа стратегического видения “Россия – Исламский мир”. – М., Институт Востоковедения РАН, 2018. 456с. (Оросын Ислам. Түүх ба соёлын найруулал. Засварлаж нэмэлт хийсэн хоёр дахь хэвлэл. “Орос улс – Исламын ертөнц” Стратегийн хараа бүлэг. М., ОХУ-ын ШУА-ийн Дорно дахин судлалын хүрээлэн, 2018, 456 тал хуудас)

Тус бүтээлийг Оросын ислам шашин судлалын нэрт эрдэмтэд болох А.К.Аликберов, В.О.Бобровников, А.К.Бустанов нар хамтран туурвиж, ОХУ-ын ШУА-ийн Дорно дахин судлалын хүрээлэнгийн 200 жилийн ойд зориулан хэвлүүлжээ.

Тус бүтээл өмнөх үг, удиртгал, үндсэн 12 бүлэг (тэдгээр нь нийтдээ 49 зүйлтэй), дүгнэлт болон гадаад нэр томъёоны орчуулгатай товч тайлбар толь, хүний нэрийн хэлхээ, товчилсон үгсийн жагсаалт, ашигласан эх сурвалж, ном зүйг багтаасан хавсралттай юм. Зохиогч

А.К.Аликберов, В.О.Бобровников нар Өмнөх үгэнд энэхүү бүтээлд Орос дахь ислам шашин, түүний шашны номлолын дэг сургууль, сургаал, оюуны соёл, мусульманчуудын шашин шүтэх практик, ислам шашны байгууллагуудын түүхэн хөгжлийн олон талтай асуудлыг VII зуунаас одоо үеийг багтаасан байдлаар шашны түүх-соёлын үүднээс шинжлэн боловсруулах зорилт тавьсан хийгээд түүнийг хэрхэн яаж хэрэгжүүлсэн тухай тоймлон өгүүлжээ. Зохиогчид дурдсан асуудлыг одоогийн ОХУ-ын нутаг дэвсгэрт оршин сууж байсан угсаатан, ард түмнүүдийн амьдралд ислам шашин VII зуунаас нэвтэрч эхэлсэн үе, нэгдсэн Орос улс байгуулагдаж улмаар Оросын эзэнт гүрэн бий болж хүчирхэгжсэн ба Зөвлөлт Холбоот Улс 70 гаруй жил оршин тогтсон, түүний дараах ОХУ-ын 30 гаруй жилийн түүхийн хүрээнд авч үзсэн; ислам шашин дэлгэрч баримтлагдсан үндсэн бүс нутаг бол Хойд Кавказ Урал ба Ижил мөрний эрэг бүхий сав газар, Крым, гэхдээ харьцангуй бага судлагдсан Хойд Кавказ ба Баруун Сибирьт илүү анхаарал хандуулах; шашны номлолын тэргүүлэх дэг сургуулиуд нь ашаритын болон матуридын чиглэлтэй калам сүсэгтнүүдийн баримталж шүтдэг шашны практик урсгал нь ханафит ба шафитын мазхаб болохыг судалгааны ажлын гол объект болгон сонгож шинжилснийг тайлбарлан өгүүлжээ.

Зохиогчид мөнхүү өмнөх үгэнд дээр дурдсан өргөн бөгөөд гүн нарийн асуудлыг нэг бүтээлд бүрэн төгс хамруулж, нарийвчлан авч үзэж шинжлэх нь ихээхэн ээдрээ бэрхшээлтэй учраас тус бүтээлийг түүх-соёлын шинжилгээний чанартай найрууллын /очерк/ хэлбэрээр туурвиж бичих, гэхдээ асуудалд тойм, өнгөц байдлаар хандахгүй байх, өмнө хийгдсэн

судалгаа, түүний үр дүнд гарсан бүтээлүүдийн агуулгыг давтахгүй байхын зэрэгцээ Оросын сонгодог уламжлалтай Дорно дахин судлал дахь ислам судлалын уламжлал, тэргүүний ололт амжилтын давуу талыг чухалчлан анхаарчээ. Үүний зэрэгцээ түүхэнд гарч байсан түүний түүхэн хязгаарлагдмал тал, гуйвуулга, үзэл сурталжилтыг даван туулахыг хичээх асуудалд орчин үеийн онол, арга зүйн шинэ хандлагаар хандан судалгааны гол зарчим, чиглэл болгож баримталсныг онцлон тэмдэглэсэн байна.

Зохиогчид өмнөх үгэндээ Оросын болон гадаадын эрдэмтэд Орос дахь ислам шашныг судлахдаа голцуу гадаад орнууд болон ОХУ-ын архив дахь баримт бичиг, орос хэлээр байгаа албан ёсны мэдээ материалыг гол эх сурвалж болгож баримтлаад харин тус улсын ислам шашинтай угсаатан, ард түмнүүдээс төрж гарсан бичиг номын хүмүүсийн бичиж тэмдэглэсэн гар бичмэл, эх сурвалж, аман түүх, мэдээ баримтыг ихэнхдээ орхигдуулсаар ирсэн явдал Орос улс дахь Ислам шашны түүх ноцтой гуйвуулагдсан байдгийг онцлон тэмдэглээд өөрсдийн энэ бүтээлдээ тэдгээр ховор чухал түүхэн эх сурвалж, гар бичмэл, аман түүх, бусад мэдээ баримтыг шинжилж, ислам шашны түүхийн судалгааны эргэлтэд анх удаагаа оруулж байгаагаа дурдсан байна. Энэ нь авч үзэн буй хамтын бүтээлийн жин дарах чухал ололт, шинэлэг тал болсныг үнэлж дурдвал зохино.

Орос улс дахь ислам шашны түүх, соёл, угсаатан зүйн асуудлыг судлахдаа тэдгээрийг тусгаж илэрхийлсэн араб, перс, түрэг хэлний үг, ойлголт, нэр томъёоны зэрэгцээ эл шашныг шүтэн баримталдаг уугуул угсаатан, ард түмнүүдийн утга зохиолын болон аман ярианы хэл, орон нутгийн аман аялгууны үг хэллэгийг

түүхийн болон угсаатны хэл шинжлэлийн үүднээс нягт нямбай хандаж авч үзэх шаардлагатай бөгөөд энэ нь дээр дурдсан гол асуудлын судалгаанд багагүй учир холбогдолтой болохыг судлаачид Өмнөх үгийнхээ төгсгөлд тайлбарлан өгүүлжээ.

Авч үзэн буй бүтээлийн энэхүү өмнөх үг нь хэдийгээр харьцангуй богино, гурван тал хуудас байгаа боловч зохиогчид түүндээ судалгааны зорилго, тодорхой зорилтын зэрэгцээ онол, арга зүйн чанартай хэд хэдэн чухал санаа бодол хэлсэн нь тус өмнөх үгийг жинтэй, эрдэм шинжилгээний утга агуулгатай болгожээ. Тэгэхдээ зохиогчид тус бүтээлд Орос улс дахь ислам шашны түүх, соёл, орчин үеийн асуудлыг авч үзэж шинжлэх онол, арга зүйн болон судалгааны арга, хандлагын талаар бүтээлийн дараагийн хэсэг бүхий удиртгалд дэлгэрэнгүй өгүүлснийг тоймлон авч үзье.

Бүтээлийн Удиртгал нь “Оросын ислам” гэсэн ойлголтыг тодорхойлох асуудалд” (зохиогч нь А.К.Аликберов), “Орчин үеийн Орос улс дахь ислам шашны түүх бичлэг” (зохиогч нь В. О. Бобровников) гэсэн хоёр зүйлтэй. А.К.Аликберов нэгдүгээр зүйлд “Орос улсын ислам шашин” гэх ойлголтын утга агуулгыг тусгайлан авч үзэж тодорхойлох нь энэ асуудлын судалгаанд онол, арга зүйн учир холбогдолтой болохыг онцлон тэмдэглээд дараах санаа бодлыг хэлжээ.

Нэгдүгээрт, “Орос улсын ислам шашин” гэсэн ойлголт, түүний тусгаж илэрхийлсэн үзэгдэл, бодит байдлыг түүхийн үүднээс өргөн утга агуулгаар авч үзэж ойлгох хэрэгтэй. Орос улсын ислам шашин өөрийн түүхэндээ зөвхөн Хойд Кавказ, Крым, Урал ба Ижил мөрний сав газар, Баруун Сибирь төдийгүй Төв Ази ба

Өмнөд Кавказын угсаатан, ард түмнүүдийн ислам шүтлэгийг ч хамруулан багтааж байсан түүхтэй. ЗХУ задарч оршин тогтнохгүй болсны дараа урьд нь түүний харьяа бүрэлдэхүүнд байсан Төв Азийн бүгд найрамдах улсуудаас Оросын Холбооны Улсад нэг сая гаруй мусульманчууд шилжин ирж суурьшин тус улсын харьяат иргэн болжээ. Үүний дээр Кавказ төдийгүй Тажикстан, Узбекистан, Киргизстан, Казахстан, Азербайжанаас олон мянган иргэн ОХУ-д байнгын болон улирлын чанартай ажил хөдөлмөр эрхэлж янз бүрийн хугацаагаар оршин суухдаа өөрсдийн уламжлалт ислам шашныг шүтэн баримталдаг нь ОХУ дахь мусульманчуудын багагүй хэсгийг эзэлж байгаа ажээ. Гиймээс ОХУ дахь ислам шашны түүх ба орчин үеийн асуудлыг авч үзэхдээ энэхүү түүхэн бодит байдлыг орхигдуулж болохгүйг тэмдэглэжээ.

Хоёрдугаарт, “Оросын ислам” гэсэн ойлголтыг эрдэм шинжилгээний ажилд болон практик амьдралд хэрэглэх нь энгийн жирийн уншигчид төдийгүй зарим судлаачдын ч эргэлзээ, үл ойлголцлыг төрүүлж болох юм. Тийм эргэлзээ, ойлгомжгүй байдал үүсэх учир шалтгаан ч бий. Тэр нь юу гэвэл ер нь аливаа шашин, түүний дотор ислам шашныг түүний дэлгэрч тогтсон аль нэг улс орон, газар зүйн бүс нутаг, шүтэн баримталдаг аль нэг угсаатан ард түмэнд өмч мэт хамаатуулж тухайн орон, тив, бүс нутаг, үндэстэн угсаатны нэрээр, тухайлбал Иран, Сири, Ирак эсвэл Азербайжан, Тажикстан улсын ислам шашин, Төв Азийн, эсвэл Ойрх Дорнодын ислам шашин, узбек, казак, татаруудын ислам шашин гэх мэтээр хязгаар, ялгаа тогтоож нэрлэх нь явцуу бөгөөд түүхэн уламжлал, шашин шүтлэгийн бодит амьдралын

хувьд учир дутагдалтай юм. Учир нь дэлхийн том гурван шашин, түүний дотор ислам шашин нь өөрийн номлол, философийн сургаал, шашны зан үйл, уламжлалаараа нэгдмэл, бүхэл чанартай бөгөөд түүгээрээ аль нэг улс орны хил хязгаар, аль нэг ард түмний амьдралын хүрээ, орон зайгаар огт хязгаарлагдахгүй. Гэвч дэлхийн хэмжээний гурван шашны нэг болох ислам шашин нь хэдийгээр нэгдмэл нэг том шашин боловч дэлгэрч тогтсон тив, бүс нутаг, улс орон, шүтэж баримталдаг угсаатан, ард түмнүүдийн бодит амьдралд тэдгээрийн, тус тусын онцлог, түүх уламжлал, соёлын ялгаатай байдлаар нөхцөлдсөн багагүй ялгаа, онцлогтой байдаг. Тухайлбал, ислам шашны өлгий нутаг болох Саудын Араб улс дахь ислам шашин ба ОХУ, эсвэл Индонез улс дахь ислам шашин өөр хоорондоо өвөрмөц онцлог, мэдэгдэхүйц ялгаатай. Ислам шашин дэлгэрсэн улс орнуудын ард түмнүүдийн шашны сэтгэгчид эл шашны соёл, уламжлал, шашин шүтэх бодит практик, шашны сэтгэлгээнд өөр өөрийн хувь нэмрийг оруулж зохих онцлог, ялгаатай болгосон байдаг. Ийм түүх, уламжлал, соёл, бодит амьдралаар нөхцөлдөн тодорхойлогдож татаруудын ислам шүтлэг нь Умард Кавказын ард түмнүүдийн ислам шүтлэгээс, тэднийх арабчуудын ислам шүтлэгээс мэдэгдэхүйц ялгаа онцлогтой болно. Чухам ийм учир шалтгаан, утга агуулгаар Дундад зуун, шинэ үеийн Орос улс, одоогийн олон угсаатан, ард түмэнтэй ОХУ дахь ислам шашныг “Оросын ислам” гэж онцлон тодотгож нэрлэх бүрэн үндэслэлтэй бөгөөд энэхүү ойлголт ба түүнийг хэл зүйн үүднээс тэмдэглэж нэрлэсэн “Оросын ислам” гэсэн нэр томъёог судалгааны ажилд конструкт буюу зохион бүтээх “багаж хэрэгсэл” болгож хэрэглэх бүрэн

боломжтой юм. Энэхүү ойлголт одоогийн ОХУ-ын түүхэн ба орчин үеийн хил хязгаар, нутаг дэвсгэрт оршин суугаа мусульманчуудын ислам шүтлэгийн ерөнхий, нийтлэг шинж чанар, нэгдмэл байдлыг илэрхийлэн тэмдэглэж, шинжлэн таньж мэдэх судалгааны ажлын, “багаж хэрэгсэл” болж чадна. Гэхдээ Орос улсын түүхийн томоохон үе шат, эрин цагуудад ислам шашны дэлгэрэлт, бодит амьдрал дахь практик баримтлал, гадаад нөхцөл орчин ба дотоод үйл явц, тодорхой үйл явдлууд нь тухайн түүхэн цаг үеүдэд хоорондоо мэдэгдэхүйц ялгаа, онцлогтой байсан учраас “Оросын ислам” гэж нэрлэн буй шашны түүх, соёлыг бүхэлд нь Орос улсын түүх, түүний томоохон үе шатуудтай нягт холбож асуудалд түүхэн тодорхой хандах зарчмаар судлах ёстой.

Аль нэг шашныг, түүний дотор ислам шашныг тодорхой нэг улс орны нутаг дэвсгэрээр хязгаарлан хэмжиж судлах нь онцгой гойд шинэ зүйл биш ажээ. Франц улсад мусульманчуудын шүтлэг бишрэлийг зохицуулсан дүрэм батлагдаж гарсны дараа эрдэмтэн судлаачид “Францын ислам шашин”-ыг (islam français) улс төрийн талаар хүлээн зөвшөөрөх тухай ярилцах болжээ. Англи улсад “Британийн ислам шашин”-ыг экстремист үзэл суртлын нөлөөнөөс ангижруулан цэвэрлэх хөдөлгөөн өрнөж байгаа бөгөөд энэ асуудлыг авч үзэж хэлэлцдэг “The British Islam Conference” гэх бага хурал жил бүр хуралддаг. Үүнтэй нэгэн адилаар Германд “германы ислам шашин” гэсэн сэдэвтэй бага хурал Турк улсын идэвхтэй оролцоогоор мөн жил бүр болдог. “Америкийн ислам шашин”-ы талаар АНУ-д, Оксфорд, Кембрижийн их сургуулиас гаргадаг ном бүтээлд байнга бичдэг болж байна.

Ислам шашныг орон судлалын (страноведение) загвараар авч үзэж судлах нь өөрийн давуу тал, танин мэдэхүйн чухал ач холбогдолтой юм. Энэхүү загвараар тухайн улс орны мусульманчуудын угсаатны соёл, ёс заншил, түүх, уламжлал, нийгэм-улс төрийн амьдрал, ислам шашныг шүтэн баримтлах бодит практик, эл шашныг тухайн угсаатан, ард түмэн өөрийн амьдрал, соёлтой уялдуулан сэргээн мандуулж, гаднын экстремист, фундаменталист шашны байгууллага, урсгал чиглэлийн нөлөөнөөс ангид байдлаар зүй зохистой шүтэн баримтлах нөхцөл, арга зам зэрэг өргөн олон сэдвийг хамруулан шинжлэх бололцоотой болдог бөгөөд үр дүнд нь тухайн орон дахь ислам шашны бодит байдал, шинж төрх илүү их тодорхой бүрэн дүр зурагтай болж чадна.

Судалгаанд “Орос улсын ислам шашин” гэсэн ойлголтыг хэрэглэхтэй холбоотойгоор “оросын мусульман” (русское мусульманство) гэсэн ойлголт анхаарал татдаг. Эл ойлголтыг шашин, нийгэм-улс төр, утга зохиолд Орос орон дахь ислам шашныг шинэтгэх хөдөлгөөнийг үндэслэн үүсгэгчдийн нэг Исмаил Гаспиринский анх 1881 онд гаргаж хэрэглэжээ. Эл ойлголт эхэндээ Оросын эзэнт гүрний үед Кавказ, Крым, Урал ба Ижил мөрний сав газар, Туркестан, Тал нутаг (Казахстан), Баруун Сибирьд оршин суудаг, уламжлалт ислам шашныг шүтэн баримталдаг угсаатан, ард түмнүүдийг нэрлэн илэрхийлж байв. Энэ ойлголтын зэрэгцээ ислам шашинд шинээр орж шүтэн баримтлах болсон цэвэр орос угсаатнуудыг нэрлэх зорилгоор “орос мусульманчууд” (русские мусульмание) гэсэн нэр бүхий ойлголт ч гарсан байна.

Энд дээр дурдсан “Орос улсын ислам шашин”, “Оросын мусульман”, “Орос мусульманчууд” гэсэн ойлголтууд хэн нэг эрдэмтэн судлаачийн санааны зоргоор эсвэл санамсаргүй аяндаа үүсэж бий болсон зохиомол үг хэллэг биш, харин бүхэлдээ Орос улсын харьяат иргэн болж аж төрж байсан ислам шашинтай янз бүрийн угсаатан, ард түмнүүдийн ислам шүтлэгийн онцлог, ялгаатай байдлыг тусгаж илэрхийлсэн ойлголтууд ажээ. Эдгээр ойлголт ислам шашныг өөрсдийн угсаатны уг шинж, уламжлал, соёлын тодорхой ялгааны дагуу зарим талын онцлогтойгоор шүтэн баримталж ирсэн татаар, башкир, Хойд Кавказын олон угсаатны ислам шүтлэгийн оюун санааны болон практик амьдрал дахь онцлог, ялгааг түүхэн харьцуулалтын аргаар судлахад чухал ач холбогдолтой болно.

Тийнхүү бидний дээр тоймлож өгүүлсэн багц үзэл санаа бол тус номын удиртгалын нэгдүгээр зүйлд зохиогч А.К.Аликбероваас дэвшүүлэн тавьж судалгаандаа баримталсан онол, арга зүй, асуудалд шинээр хандах талаарх чухал үзэл баримтлал юм гэж үнэлэн дүгнэж байна.

Удиртгалын хоёрдугаар зүйлд зохиогч, доктор, профессор В.О.Бобровников ЗХУ задран нурсны дараах өргөн уудам орон зай дахь уламжлалт ислам шашны угсаатны болон соёлын баялаг өв сан янз бүрийн талаасаа тодорхой хэмжээнд судлагдаж олон ном бүтээл хэвлэгдэж гарсны дотор олон улсын судалгааны үр дүн болох “Хуучны Оросын эзэнт гүрний нутаг дэвсгэр дэх ислам шашин” (Ислам на территории бывшей Российской империи) нэртэй нэвтэрхий толь чухал байр суурь эзэлж байгаа бөгөөд түүний дараа мөн сэдвээр цуврал

бүтээлүүд гарч байгааг үнэлж дурдаад Орос дахь Ислам шашны түүх, соёл, орчин үеийн асуудлаар XIX зуунаас хойш хийгдсэн судалгааны тойм буюу түүх бичлэгийг дэлгэрэнгүй авч үзэж шинжилжээ. Энэ талаар зохиогчоос чухалчлан авч үзэж үнэлэлт дүгнэлт гаргасан асуудал, үзэл санааны заримыг тоймлон өгүүлье.

XX-XXI зууны зааг дээр ер шашин, түүний дотор Орос улс, ЗХУ дахь ислам шашны түүх, соёлыг судалж ирсэн үзэл сурталжсан онол, арга зүй үеэ өнгөрөөж баримтлагдахгүй болсноор нэг талаар түүний түүхэн хязгаарлагдмал шинж, алдаа гуйвуулга зэрэг дутагдал, сул талыг илчилж гаргах, түүнээс сануулга, сургамж авах, нөгөө талаар ислам шашны судалгаанд шинэ үзэл баримтлал, арга хандлагаар хандах зорилт тавигдаж энэ чиглэлээр нэлээд ажил хийгдсэн ажээ.

Зохиогч Орос улс дахь ислам шашны асуудлаар XIX-XX зуунд хийгдсэн судалгааны түүх бичлэг үндсэндээ гурван том уламжлалт чиглэл бүхий дэг сургуультай байсан нь:

1. Хуучны академик шинж чанартай уламжлалт ислам судлал;
2. Зөвлөлтийн шинжлэх ухааны шашингүйн үзэл (советский научный атеизм);
3. Барууны зөвлөлт судлал (западная советология) болохыг тэмдэглээд Орос улс дахь ислам шашны асуудлаар сүүлийн 20 орчим жилд хэвлэгдсэн ном бүтээлээс дээрх 3 чиглэлтэй судалгаа буюу түүх бичлэгийн нөлөө, ул мөрийг тод ажиглаж болно гэжээ.

Эдгээр гурван дэг сургуулийн сүүлийн хоёр нь XIX зуунд Оросын эзэнт гүрний үед бий болж хөгжсөн гэж үздэг ажээ.

Казаний шашин номлогч чиглэлтэй дорно дахин судлалын дэг сургуулиас үзэл санааны гарал үүсэлтэй байсан боловч төдийлөн удалгүй мэргэжлийн дорно дахин судлалын шинж агуулгаа алдаж үзэл сурталжсан ажээ. Зөвлөлт засгийн үед марксист онол сурталд үндэслэж тогтсон зөвлөлтийн шашингүйн үзлийн дэг сургууль нь аливаа шашин, түүний дотор ислам шашныг шинжлэх ухаанчаар судлахаасаа илүүтэйгээр түүнтэй тэмцэх, муулж, харлуулж шүүмжлэх, гүтгэж гуйвуулах зорилт тавьж байв. Энэ чиглэлийн төлөөлөгчид 1920-иод оны дундуур байгуулагдаж 1941 онд тараагдсан “Шашингүйн дайчин үзэлтнүүдийн холбоо”-ны нурангид үндэслэж байгуулагдсан “Эрдэм” нийгэмлэгийг тойрон хүрээлж шашингүйн суртал ухуулга хийж байв. Дэлхийн II дайны дараа “Хүйтэн дайн”-ы үед Франц ба АНУ-д Александр Беннигсений үндэслэж байгуулсан зөвлөлт судлалынхан зөвлөлтийн шашингүйн үзэлтэй шашин судлаачид ислам шашныг гуйвуулан шүүмжилж байна гэж шүүмжилдэг байсан боловч өөрсдөө ислам шашныг жинхэнэ холбогдох эх сурвалжаар биш, орос хэлээр гарсан албаны баримт материалд тулгуурлан хэлбэр төдий авч үзэж байжээ.

ЗХУ задран нурсны дараа, мөн социализм, капитализмын хоорондын “хүйтэн дайн” төгсгөл болсноор Зөвлөлтийн шашингүйн үзэл ба зөвлөлт судлал нь шашин судлалын салбараас шахагдаж алга болсон боловч эл хоёр чиглэлийн бий болгож хэрэглэсэн арга, хандлагын хэвшмэл загвар орос болон барууны орчин үеийн шашин судлаач, улс төр судлаачдын сэтгэлгээ, арга

хандлагад тодорхой хэмжээгээр үргэлжлэн баримтлагдсаар байгааг зохиогч В.О.Бобровников тодорхой баримтуудаар авч үзэж шүүмжилжээ. Тэрээр түүнчлэн ОХУ-д ислам судлалаар сүүлийн хориод жилд шинэ эрэл хайгуул хийсэн, асуудалд шинээр хандахыг оролдсон ном бүтээл нэлээд гарсан, ялангуяа Оросын ислам шашинтай угсаатан, ард түмнүүдээс төрж гарсан уугуул эрдэмтэн судлаачид ислам шашны түүх, соёл, түүний дотор өөрийн ард түмэн, сүсэгтнүүдийн ислам шүтлэгийг холбогдох чухал эх сурвалж, мэдээ материалаар илүү тодорхой судалж байгаа зэрэг ололт амжилт, ахиц дэвшлийн талаар дэлгэрэнгүй авч үзэж анхаарал татах үнэлэлт дүгнэлт хийсэн нь нэн сайшаалтай бөгөөд бусад судлагчдад шинэлэг санаа бодол төрүүлэхүйц байгааг онцлон тэмдэглэе.

Зохиогчид тус бүтээлийн Өмнөх үг, Удиртгал хэсэгт Орос улс дахь ислам шашны түүх, соёл, угсаатны зүйн болон орчин үеийн асуудлыг шинэлэг үзэл баримтлал, арга хандлагаар судлах онол, арга зүйн чанартай чухал асуудлуудыг авч үзэж өөрсдийн үзэл санаа, үнэлэлт дүгнэлтээ тодорхой өгүүлж томъёолсон байгаа тул бид тэдгээрийг илүү дэлгэрэнгүй өгүүлэв. Энэ нь ислам шашныг судалдаг эрдэмтдийн анхаарлыг татах, санал бодол солилцож хэлэлцвэл зохих чухал хэсэг юм.

Тус бүтээл 12 бүлэгтэй, тэдгээр нь нийлбэр хэмжээгээрээ том байгаа учраас тэдгээр бүлэг тус бүрийн агуулга, утга санаа, зохиогчдын хийсэн үнэлэлт дүгнэлт, шинэлэг үзэл бодлыг дэлгэрэнгүй авч үзэж уншигчдад санаж хүссэнээр дамжуулж танилцуулах боломж энэхүү бэсрэг тэмдэглэлд хомс байгаа тул

тэдгээрт авч үзсэн асуудлын тоймыг л товчлон өгүүлж байна.

Бүтээлийн нэгдүгээр бүлэг “Орос улсын ислам шашны эх үүсвэр” гэсэн нэртэй бөгөөд дотроо бие даасан 4 зүйлтэй юм. Эл бүлгийг бүхэлд нь А.К.Аликберов бичжээ. Бүлэгт VII-VIII зуунд Дундад Ази, Кавказ, Урал ба Ижил мөрний сав газрын угсаатан ард түмнүүдийн дунд ислам шашин анх нэвтрэн дэлгэрсэн асуудлыг урьд өмнө энэ талаар гарсан ном бүтээлд бараг дурдагдаж байгаагүй нэн чухал, шинэ мэдээ баримтуудаар авч үзсэн нь тус хамтын бүтээлийн маргашгүй үнэ цэний нэг мөн байна.

Зохиогчийн авч үзсэн асуудал, өгүүлсэн үзэл санааг дамжуулж товч дурдвал Арабчуудын байлдан дагуулал, эзэлсэн бүс нутагт ислам шашныг нэвтрүүлж дэлгэрүүлсэн эхний үе буюу VII зууны дунд үед Кавказ, Урал, Ижил мөрний сав газрын угсаатан ард түмнүүд Хазарын хант улсын харьяанд байсан бөгөөд тус хант улсад ислам, иудайн болон христийн шашин нэвтэрсэн байжээ. Арабчууд эхэндээ эл бүс нутагт ислам шашныг байлдан дагуулалтай нэгэн зэрэг хослуулж хүч хэрэглэх замаар, улмаар Кавказ, Дундад Ази нь Халифат гүрний эрхшээлд орсноор VIII зууны дунд үеэс эдгээр нутаг оронд Халифат гүрний төв хэсэг, Палестин ба Сирийн нутгаас мусульман иргэд, гэр бүлүүдийг олон мянгаар нь нүүлгэн авчирч суулгаснаар эдгээр нутагт ислам шашин дэлгэрч баримтлагдах үйл явц эрчимжиж XIII зууны дунд үе хүртэл үргэлжилж жигдрэн тогтсон байна. Ислам шашин тийнхүү нэвтрэн дэлгэрэх явцад тус шашны янз бүрийн урсгал чиглэл, философи, нийгэм-улс төр, хууль эрх зүйн



номлол сургаал мөн зэрэгцэн нэвтэрч шашин шүтлэгийн практикт баримтлагдах болжээ.

Энд онцлон тэмдэглүүштэй зүйл бол зохиогч Дундад Ази, Кавказ, Ижил мөрний сав газарт ислам шашин анх түрүүн арабын байлдан дагууллын хүчээр нэвтэрсэн асуудлыг авч үзэхдээ бүр Мухаммедын хамтран зүтгэгч болох Умар ибн аль-Хаттаб, тэр цагийн бичиг номын хүн Ат-Табари зэрэг түүхэн бие хүмүүсийн бичсэн зүйл, тэмдэглэл, Персийн түүхч эрдэмтэн Мухаммад Нар-Шахийн зохиол бүтээлийг чухал эх сурвалж болгон ашигласан явдал юм. Зохиогч түүнчлэн Кавказад ислам шашин нэвтэрч дэлгэрсэн асуудлын талаарх энэхүү уулын орны ард түмнүүдийн аман түүх, хууч яриа, домог зэрэг баялаг мэдээ материалыг нарийвчлан шинжилсний үндсэн дээр өргөн ашиглажээ.

Тус бүлгийн 3, 4 дүгээр зүйлд Зүүн Хойд Кавказад ислам шашныг нэвтрүүлэн дэлгэрүүлэх үйл явдалд оролцсон Мухаммадын хамтран зүтгэгчдийн намтар түүх, шашин, улс төр, цэргийн үйл ажиллагаа, Хойд Кавказад арабчууд хамгийн анхны мечети (мечеть-ислам шашны сүм) одоогийн Дагестаны нутаг дахь эртний Дербент хотод 733 онд байгуулсан, энэ сүм нь Орос улсын нутаг дэвсгэр дэх эртний бөгөөд хамгийн анхны мечеть болохыг олон тооны мэдээ баримтуудын үндсэн дээр дэлгэрэнгүй авч үзсэн байна.

Бүтээлийн “Орос улсын ислам шашны хэлбэршлийн үе” гэсэн хоёрдугаар бүлэг, “Дэлгэрэлт ба төлөвшлийн үе” гэсэн гуравдугаар бүлгийг мөн адил А.К.Аликберов бичжээ. Тэрээр эдгээр бүлэгт ислам шашин IX-X зуунд Кавказ, бусад нутаг оронд гаднын хүч нөлөө, шашин нэвтрүүлэх үйл ажиллагаагаар

биш, харин өөрийн дотоод үйл явц, хүчин зүйлсийн дагуу дэлгэрч хэвшин тогтсон; энэ үед тухайн нутаг орны шашны бичиг номын мэргэд ислам шашны үзэл санаа, номлол, шашин шүтлэгийн практик үйл ажиллагааны талаар ном бүтээл бичиж туурвих болсон; ислам шашны номлолын ашарийа ба матуридийа урсгал чиглэл нэвтрэн дэлгэрч баримтлагдах болсон; Оросын нутаг дэвсгэрт монголчууд халдан довтолж ноёрхлоо тогтоосон явдал XIII-XIV зуунд Орос оронд ислам шашин өөрийн дотоод үйл явцын дагуу улам бүр дэлгэрч идэвхтэй, хүчтэй баримтлагдах шинэ үе шатны эхлэлийг тавьсан; Ираны Сефевидүүдийн эрх баригч шахуудын шашны үйл ажиллагааны үр дүнд Азербайжанд ислам шашны шиит чиглэл (шиизм) өргөн дэлгэрсэн; Кавказын өндөр уулын нутаг орон- Чечень, Ингушет, Балкар, Карачай ба Осетины хүн амын зарим хэсэгт ислам шашин XVII-XVIII зуунд дэлгэрэн баримтлагдсан; ер нь энэхүү үйл явц XIX зуунд бүрэн гүйцэд төгсгөл болсон; эдгээр дурдсан нутаг оронд ислам шашны суфизмын чиглэлтэй зан үйл, ёс заншил хэвшин тогтсон асуудлыг зохиогч холбогдох арвин баримт материалд тулгуурлан авч үзсэн байна.

Зохиогчид хамтын бүтээлийн “Оюун санааны ерөнхий орон зайн төлөвшил” гэсэн 4 дүгээр бүлэгт Оросын эзэнт гүрэн байгуулагдан хүчирхэгжиж түүний ноёрхолд Казаны хант улс 1552 онд, Астраханы хант улс 1566, Крымын хант улс 1783 онд, Казахын Дунд зуут 1731, Бага зуут 1787 онд тус тус харьяалагдаж орсноор, мөн Сибирийг эзлэх үйл явц 1581 онд эхэлсэн хийгээд ер XIX зуунд Төв Ази бараг бүхэлдээ, Кавказ бүрнээр Эзэнт гүрний бүрэлдэхүүнд орж харьяалагдсанаар эдгээр бүс нутаг, газар орны

мусульманчууд шашны оюун санааны нэгдсэн нэг орон зайд аж төрж, эдгээр уугуул мусульманчуудын өөрсдийн нь хувраг санваартнууд төлөвшин бий болж шашин номын үйл ажиллагаа явуулах болсон; энэ үед зарим нутаг оронд ислам шашны ном судар, бичиг, тэмдэглэл зэрэг бүтээлүүд перс хэлээр бичигдэж байсан; Орос улсын мусульманчууд ислам шашныг шүтэн баримтлахдаа Коран судар ба Сунна шаштирт бичигдсэн хатуу баримтлагдах ёстой хэм хэмжээ, зан үйл болон шашны тулгуур номлол, сургаалыг зохих ёсоор шүтэн баримталж байсны зэрэгцээ тэдгээрийг тухайн угсаатан, ард түмэн яг бодит амьдрал дээр өөр өөрийн түүх, соёл, уламжлал, ёс заншлын нөлөө, өнгө аясаар зарим талын ялгаа, онцлог шинж илрэлтэйгээр шүтэн баримталж байсныг зохиогчид авч үзээд энэхүү үзэгдэл, үйл явдлыг “цэвэр” ба “ард түмний” ислам гэж нэрлэсэн байна. Энэ асуудалтай холбогдуулж шашны, түүний дотор ислам шашны экстремизм, шашны тулгуур үзэл (фундаментализм), тэдгээрийн үүслийн үндэс шалтгааныг авч үзжээ.

Бүтээлийн “Их гүрний засаг ба мусульманы хуврагууд” гэсэн 5 дугаар бүлэг нь Оросын мусульманчуудын дээд давхраа (элит) Оросын эзэнт гүрний засаг захиргаа, цэрэг арми, орон нутгийн удирдлага зэрэг салбар, бодлого, үйл ажиллагаанд оролцож үүрэг гүйцэтгэж байсан асуудал; Оросын эзэнт гүрний төр засаг ислам шашныг албан ёсоор хүлээн зөвшөөрч XVIII-XIX зууны зааг дээр эл шашны үйл ажиллагааг төрийн нэгдсэн бодлогод нийцүүлж зохицуулах удирдлагын өвөрмөц тогтолцоог бий болгож удирдах болсон хийгээд тэр явцад гарч байсан зарим зөрчил бэрхшээл; Оросын эзэнт гүрний

төр засаг харьяат мусульманчуудын амьдрал, үйл ажиллагаа, аж ахуй, хүмүүсийн хоорондын болон гэр бүлийн харилцаа, гэмт хэрэг, зөрчлийг төрийн хууль цааз, эрх зүйгээр зохицуулахын зэрэгцээ ислам шашны эрх зүй, тухайн угсаатан, ард түмний ердийн эрх зүй буюу уламжлалт ёс заншлын хэм хэмжээгээр зохицуулах талаар ч анхаарч байсан зэрэг үндсэн асуудлыг холбогдох олон янзын мэдээ баримтуудыг шинжлэн ашиглах үндсэн дээр авч үзэж судлан боловсруулахад зориулагдсан байна.

Хамтын бүтээлийн “XVIII зууны төгсгөл-XIX зууны эхэн дэх Орос улсын ислам шашны бичиг номынхны шашны сургаал ба эрх зүйн талаарх маргаан” гэсэн 6 дугаар бүлэгт тус оронд ислам шашин дэлгэрэн тогтож хэвшсэнээр түүний хувраг санваартан, бичиг номын хүмүүс шашны сургаал, гүн ухаан, ёс зүй, хууль, эрх зүйн янз бүрийн асуудлаар ном зохиол бичиж, анхаарал татсан зарим чухал асуудал, мөн зарим сэтгэгчийн ном бүтээлийн талаар санал бодол хэлж маргаан мэтгэлцээн хийх болсон тухай багц асуудлыг авч үзжээ. Бүтээлийн эл бүлгийг Амстердамын их сургуулийн профессор М.Кемпер бичжээ. Тэрээр Ижил мөрний эрэг, Урал орчмын нутгийн мусульманчуудын шашны боловсрол, бичиг номын хүмүүсийн эрдэм мэдлэг, бичсэн зохиол бүтээл, тухайлбал Татарстанаас төрж гарсан шашны сэтгэгч эрдэмтэн Абу-н-Наср ал-Курсавигийн туурвисан олон ном зохиолыг хадгалагдан уламжлагдаж ирсэн жинхэнэ эх бичиг, бусад холбогдох ном бүтээлийг нарийвчлан шинжилж бүхэл бүтэн том бүлгийн хэмжээнд дэлгэрэнгүй авч үзсэн нь тус хамтын бүтээлийн эрдэм шинжилгээний үнэ цэн, шинжлэх ухаанч шинж чанарт жин нэмсэн,

холбогдох олон мэдээ баримт, эх бичгүүдийг судалгааны ажлын эргэлтэд оруулсан чухал бүтээл болсон байна.

Хамтын бүтээлийн “Орос улсын ислам шашны суфист хэмжигдэхүүн” гэсэн 7 дугаар бүлгийг Санкт-Петербург дахь Европын их сургуулийн профессор А.К.Бустанов бичжээ. Тэрээр тус бүлэгт XIX зуунд Ижил мөрний эрэг, Урал орчмын нутаг орны шашны сургуулийн сурагч, оюутнууд, ер шашны зохих түвшний боловсролтой мусульманчууд ислам шашны суфист үзэл өргөн дэлгэрсэн Дундад Азийн Бухар хот дахь шашны дээд сургуульд олноор очиж суралцан буцаж ирээд энэхүү үзэл ёсыг нутаг орондоо сурталчлан дэлгэрүүлж нөлөөтэй болгосноор эдгээр нутаг орны шашны бичиг номын эрдэмтэд, тухайлбал Абд ар-Рахим ал-Булгари зэрэг сэтгэгчид суфизмын асуудлаар, түүнчлэн яруу найргийн болон утга зохиол судлал, хэл шинжлэлийн талаар ном зохиол бичиж туурвисныг холбогдох эх зохиол, бусад олон сурвалж бичгүүдийг нягтлан шинжилсний үндсэн дээр дэлгэрэнгүй авч үзжээ.

Авч үзэн буй хамтын бүтээлийн “Орос улсын ислам шашны хэл” гэсэн 8 дугаар бүлэгт зохиогч А.К.Бустанов Орос улсын мусульманчуудын шашны боловсрол, бичиж туурвисан ном зохиол, ер оюун санааны амьдрал, ертөнцийг үзэх шашны үзэлд Дундад Азийн ислам шашин багагүй нөлөөтэй байсны эрхээр тэнд утга зохиолын хэл болж хэдэн зууны туршид хэрэглэгдэж байсан перс хэл бичиг Орос улсын ислам шашны хэл болж тэндхийн шашны бичиг номын хүмүүс зохиол бүтээлээ перс хэлээр бичих нь зонхилж байсныг тухайн үед бичигдсэн олон эх зохиол, сурвалж бичгүүдийг шинжилсний үндсэн дээр тодорхой дэлгэрэнгүй

авч үзэж өгүүлсэн байна. Зохиогч үүний зэрэгцээ Орос улсын ислам шашны ном бүтээл, янз бүрийн бичиг баримт, тэмдэглэл, гар бичмэл нь түрэг, араб, осман, цагаадай, орос, тухайн уугуул угсаатан, ард түмний хэлээр ч бичигдэж байсныг тусгайлан авч үзсэн байна.

Бүтээлийн энэхүү 8 дугаар бүлэг Орос улсын ислам шашин, харьяат мусульманчуудын эрдэм номын хүмүүсийн туурвисан ном бүтээлийн утга зохиолын хэлний асуудлыг холбогдох олон бичиг баримт, ном зохиолын жишээн дээр бие даасан асуудлын түвшинд авч үзсэн нь Орос улсын ислам шашны түүх, соёл, утга зохиолын судалгаанд шинэлэг чухал хувь нэмэр болжээ гэж үзэж байна.

Бүтээлийн “Зөвлөлтийн ислам шашны орон зай” гэсэн 9 дүгээрт бүлэгт авч үзсэн асуудлыг тоймлон өгүүлбэл ЗХУ-ын бүх нутаг дэвсгэрт зөвлөлт засаг бүрэн тогтсоноор Большевик нам, Зөвлөлт төр шашныг даван туулах нэрээр хэрэг дээрээ шахан хориглох, бурхангүйн (шашингүйн) үзлийг сурталчлах, сүсэгтэн олны ухамсар, ертөнцийг үзэх үзлийг социалист, марксист үзэл суртлаар өөрчилж хүмүүжүүлэх бодлого явуулсан нь ислам шашин ба түүнийг шүтэн баримталдаг мусульманчуудын шүтлэг бишрэлд мөн нэгэн адил холбогдож хамаарна. Гэвч зөвлөлтийн хүн ард, түүний дотор мусульманчууд өөрсдийн уламжлалт шашнаа албан ёсны бус хүрээнд буюу ахуй, иргэд хоорондын харилцаа, итгэл үнэмшил, ёс заншлын хүрээнд тодорхой хэмжээнд баримталсаар байв. Нөгөө талаар зөвлөлт төр ислам шашныг ЗХУ-ын нийт мусульманчуудыг нэгтгэн нягтруулж зөвлөлт нийгмийн эв нэгдлийг бэхжүүлэх бодлогодоо ашиглаж байв. Зөвлөлтийн эх орны дайны дараа зөвлөлт

төрийн шашны бодлого зарим талаар өөрчлөгдсөний нэгэн чиглэл бүхий илрэл бол ислам шашны лам хувраг, удирдах болон туслах шатны бүх ажилтныг Узбекистаны Бухара хот дахь шашны дунд сургууль, Ташкентын шашны дээд сургуульд суралцуулан бэлтгэдэг болжээ. ЗХУ-д шашин шүтлэг хэдийгээр хязгаарлагдмал байсан ч гэсэн ислам шашны эрдэм номтой сэхээтэн, эрдэмтэд шашны ном бүтээл, эх сурвалжуудыг судалж, энгийн жирийн сүсэгтэн иргэд исламын сүмүүдэд очдог, мөргөл үйлддэг явдал тасалдаагүй ажээ.

Бүлэгт тусгайлан авч үзсэн асуудлын нэг нь 1910-1920-иод онд Муса Бигеев, Зия Камали, Борханетдин Шараф, Мухаммад Садик Иманкули нар Коран судрыг татаар хэлэнд хөрвүүлсэн, ялангуяа Ленинград дахь исламын сүмийн имам (хамба лам) Габделбари Исаевийн орчуулга ба түүний туурвиж бичсэн олон тооны бүтээл, гар бичмэлийн тухай юм. Гэвч Коран судрын дурдсан орчуулгууд хэвлэгдэж гараагүй ажээ. Тус бүлгийн нэг зүйлд Татарстанд 1963 онд төрсөн, ислам шашны өндөр боловсролтой бичиг номын эрдэмтэн, шашны салафизмын аядуу чиглэлийн зүтгэлтэн Идрис Галаютдины туурвисан ном бүтээл, үзэл санаа, үйл ажиллагааг авч үзжээ.

Бүтээлийн “Өөрчлөн байгуулалт ба дахин исламжуулалт” гэсэн 10 дугаар бүлэгт ЗХУ-д өөрчлөн байгуулалтын бодлого, үйл явц өрнөж, эргэлт буцалтгүй болсноор шашин шүтлэг, түүний дотор ислам шашин нийгмийн амьдрал, оюун санааны тавцанд ил тод гарч ирж дахин сэргэсэн, исламын сүм, шашны сургууль олноор байгуулагдсан, мусульманчуудын шүтлэг бишрэл, шашин номын болон зан үйлийн ажиллагаа идэвхэжсэний зэрэгцээ шашны шинж

агуулгатай нийгэм-улс төрийн үйл ажиллагаа, үзэл суртал, гадаад харилцаа ч идэвхжин өрнөсөн тухай өгүүлж, энэ нь зарим талаар нийгэм-улс төрийн чанартай зөрчил, мөргөлдөөн, гэмт хэрэг өсөж нэмэгдэхэд хүргэснийг дурджээ.

Эдгээр үйл явцыг төрийн хууль, эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах хэрэгцээ шаардлагын дагуу ЗХУ-ын Дээд зөвлөл 1990 оны 10 дугаар сарын 2-нд “Шашин шүтэх эрх чөлөө ба шашны байгууллагын тухай” хууль, ЗХУ-ын 15 Бүгд Найрамдах улсын нэг байсан Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбооны Орос Улсын (оросоор товчилсон нэр нь РСФСР) дээд зөвлөл мөн 1990 оны 10 дугаар сарын 25-нд “Шашин шүтлэгийн эрх чөлөөний тухай” хуулийг тус тус батлан гаргасан явдал зөвлөлтийн ислам шашин шүтдэг иргэдийн сүсэг бишрэл, шашин номын үйл ажиллагааны эрх чөлөөнд чухал ач холбогдолтой болжээ. Авч үзэн буй бүлгийн 3 дугаар зүйлд 1990-ээд онд Хойд Кавказад үүсэж өрнөсөн ислам шашны экстремист ваххабит хөдөлгөөн, алан хядах үйлдэл, зэвсэгт тэмцэл ба тэдгээрийн шашин-улс төр, үзэл суртал, нийгмийн шинж чанар, ОХУ-ын төр засгаас эдгээр үйл явдлыг таслан зогсоож зохицуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар тодорхой авч үзжээ.

ОХУ-ын Төрийн Думаас 1997 оны 9 дүгээр сарын 26-нд батлан гаргасан “Шашин шүтэх эрх чөлөө ба шашны байгууллагын тухай” хуульд ислам шашныг үнэн алдрын шашны нэгэн адилаар Орос улсын уламжлалт шашин, Орос улсын ард түмнүүдийн түүхэн өв соёлын нэгэн салшгүй хэсэг хэмээн тодорхойлжээ. Энд “уламжлалт ислам шашин” гэдэг нь албан ёсоор

хүлээн зөвшөөрсөн, хууль ёсны гэсэн утгатай, харин “уламжлалт биш шашин” гэдэг нь гадаадаас нэвтрэн орж ирсэн, гадаадын шашин номлогчдын бий болгосон урсгал, түүнчлэн албан ёсны уламжлалт ислам шашинд сөрөг ханддаг орон нутгийн шашны байгууллагыг багтааж ойлгосон байна.

Хамтын бүтээлийн “Орчин үеийн ислам ба улс төр” гэсэн 11 дүгээр бүлэгт ЗХУ оршин тогтнож байсан үед зөвлөлт засгаас ислам шашны үйл ажиллагааг зохицуулж байсан хууль, эрх зүйн хэм хэмжээ, бий болгосон удирдлага, зохион байгуулалтын бүтэц нь ЗХУ задран нурсны дараах ОХУ-ын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй уламжлалт ислам шашинд ямар үр дагавар үлдээсэн, түүний нөлөөг орчин үеийн шашны амьдралын шинэ хэрэгцээ, шаардлагаар хэрхэн зохицуулж, даван туулж байгаа асуудлыг холбогдох хууль тогтоомж, төрийн бодлогын тодорхой арга хэмжээнүүдийн жишээн дээр болон Хойд Кавказ дахь ислам шашны нөхцөл байдал, “уламжлалт ислам” гэдэг ойлголт, түүний бодит практикийн талаарх татаарын шашны зүтгэлтэн, бичиг номын нэр нөлөөтэй төлөөлөгч Валиулла Якуповын үзэл санаа, байр суурьтай холбож авч үзсэн байна.

Номын “Орос улсын ислам шашны өнөөгийн байдал ба хэтийн төлөв” нэртэй төгсгөлийн 12 дугаар бүлэгт ОХУ-ын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ислам шашны байгууллага, сүм, янз бүрийн шатны шашны сургууль, түүнийг төгсөгчдийн тоо, статистик мэдээ баримт, шашны сургуулиудын сургалт, орчин үеийн залуу, өсвөр насныхны шашны ухамсар, байр суурь, түүнчлэн нийт мусульманчуудын амьдрал, үнэт зүйлийн

тогтолцоонд “уламжлалт ислам шашны” оюун санааны үнэт зүйл, эрхэмлэл, хэм хэмжээ хэрхэн яаж төлөвшин хэвшиж байгаа тухай асуудал, ер тус орон дахь ислам шашны ирээдүй, хэтийн төлөвийг авч үзжээ.

Бүтээлийн Дүгнэлтийн хэсэгт 2013 оны 10 дугаар сарын 22-ны өдөр ОХУ-ын нэг субъект - Бүгд Найрамдах Башкортостан улсын (хуучны нэрээр Башкир) нийслэл Уфа хотноо хуралдсан ОХУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх үндэстэн хоорондын харилцааны хөгжлийн асуудлаарх зөвлөлийн хуралдаан дээр ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин Ислам шашны номлол сургаалын эх орны уламжлалт дэг сургуулийг сэргээн хөгжүүлэх талаар хэлсэн чухал үзэл санаа, гаргасан саналын дагуу ислам шашны боловсролын гурван шаттай тогтолцоог бий болгон хөгжүүлэх, түүнийг ислам шашны талаар гаднаас орж ирж буй шашны элдэв сургаал, урсгал, суртал ухуулгын эсрэг тавьж ислам шашны эх орны зүтгэлтэн, эрдэм номын боловсон хүчнийг сургаж бэлтгэх, бүхэлдээ уламжлалт ислам шашныг сэргээн шинэтгэх зорилт тавигдаж байгаа хийгээд тэр талаар хийгдэж буй ажил, олон талтай арга хэмжээ, тэдгээрийн үр дүнгийн тухай санаа бодлыг нэгтгэн дүгнэж өгүүлсэн байна.

Бүтээлийн Хавсралтын эхний хэсэгт ислам шашны номлол сургаал, шүтлэг, практик баримтлалтай холбоотой араб, перс, түрэг, чечень хэлний үг, ойлголт, нэр томъёоны орос орчуулгатай товч тайлбар толь (глоссарий), дараагийн хэсгүүдэд хүний нэрийн хэлхээс товчилсон үгийн жагсаалт, бүтээлд ашиглаж эш татсан эх сурвалж, англи, орос, татаар, дагестан хэлээрх утга зохиолын ном зүйг жагсаажээ.

Монголын шашин судлаач эрдэмтэд, шашин судлалын чиглэлээр суралцаж буй оюутнууд, монголын мусульман сэхээтэн, ер нийт уншигчдад танилцуулах зорилгоор агуулга, үзэл санаа, үнэлэлт дүгнэлтийг нь тоймлож өгүүлсэн судалгааны энэхүү нэгэн сэдэвт хамтын бүтээл нь ОХУ дахь ислам шашны түүх, соёл, утга зохиол, орчин үеийн олон талтай асуудлыг судалгааны шинэлэг онол,

арга зүй, арга хандлагаар, арвин баялаг баримт материал, ялангуяа урьд өмнө судалгааны эргэлтэд орж байгаагүй чухал эх сурвалж бүхий ном зохиол, гар бичмэл, архивын баримт бичгүүдийг нягтлан авч үзэж шинжилсний үндсэн дээр бичиж туурвисан үнэ цэнтэй, шинжлэх ухаанч чанартай шинэ чухал бүтээл болжээ гэж үзэж байгаагаа төгсгөл болгож онцлон тэмдэглэе.

## NEW WORKS OF RUSSIAN ISLAM HISTORY AND CULTURE RESEARCH

*Zolboo Dashnyam*

*Institute of International Studies, Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia  
zolbood@mas.ac.mn*

*This abstract article is devoted to a review of the content of an important, new collective work of Russian Islamic scholars (authors: A.K. Alikberov, V.O. Bobrovnikov, A.K. Bustanov) "Russian Islam Essays on History and Culture" (2nd ed., corrected and supplemented, Strategic Vision Group "Russia-Islamic World" - M.: IV RAS, 2018. - 456 p.). The content of the preface, introduction, twelve chapters and the conclusion of the work is described in detail in the article in abstract form. The author of the article emphasizes the novelty, research significance and value of work, the importance and validity of the theoretical and methodological approach of the authors to the problem of the history and culture of Islam in the Russian Federation.*